2026 оны 5-р сарын 27

ХАХУУЛЬ АВСАН ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛЛЭЭ



Энэхүү мэдээлэл нь иргэдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийтэд Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн талаарх ойлголт, хэргийн шийдвэрлэлтийг ойлгомжтой байдлаар мэдээлэх зорилготой.

Прокурорын байгууллагаас 2026 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан 263 хүнд холбогдох 114 хэрэгт яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн байна.

Нийслэл болон Төв, Архангай аймгийн прокурорын газраас өнгөрсөн 7 хоногт буюу 2026 оны 5 дугаар сарын 18-ны өдрөөс 22-ны өдрүүдэд хахууль авах, хахууль өгөх, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэмт хэрэгт буруутгагдсан 18 хүнд холбогдох 4 хэргийг анхан шатны шүүхээр хянан шийдвэрлүүлж, шүүхээс 17 хүнийг авлигын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, хуульд заасан эрүүгийн хариуцлага оногдуулсан байна. Шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийг тоймлон хүргэж байна.

Архангай аймгийн прокурорын газраас:

-Н.Ш нь нийтийн албан тушаалтан буюу аймгийн Э... сумын эмнэлгийн төсвийг болон эрүүл мэндийн даатгал хариуцсан нягтлан бодогчоор ажиллах хугацаандаа буюу 2023 оны 1 дүгээр сараас 12 дугаар сарын хугацаанд нийт 641 цаг 30 минут илүү цагаар ажилласан мэтээр цахим программд бүртгэж, нийт 6 сая төгрөгийн, Соёлын төвийн нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгэн ажиллах хугацаандаа 2023 оны 2-3 дугаар сард хавсран гүйцэтгэдэг 40 хувийн нэмэгдэл цалин дээр илүү цагийн бичилт хийх, дутуу суутгал хийх зэргээр нийт 978 мянган төгрөгийн цалин, хөлс илүү тооцон, өөртөө эдийн засгийн давуу байдал бий болгож төрд нийт 7 сая төгрөгийн хохирол учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг (эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн.

> Шүүхээс Н.Ш-ийг “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, нийтийн албанд ажиллах 5 жилийн хугацаагаар хасаж, 2 жилийн хугацаагаар зорчих эрх хязгаарлах ял оногдуулж шийдвэрлэсэн байна.

Иргэн танд:

Авлигын гэмт хэрэг нь хуулиар хамгаалсан нийгмийн ашиг сонирхлыг зөрчиж, тодорхой материаллаг хохирол учруулахаас гадна төрийн албанд хууль дээдлэх, шударга ёсыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж ажиллах зарчмыг ноцтой зөрчиж, төрд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулж, төрийн байгууллагын үнэлэмжийг сулруулах зэрэг хор уршиг учруулдгаараа нийгмийн аюулын шинж ихтэй.

Эх сурвалж: https://prosecutor-arkhangai.greensoft.mn/post/186